

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ 2020 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2020.12.10

Цагаандэлгэр сум

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлж, тайлагнах байгууллага	2020 он		Хувь
					Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжилт, үр дүн	
НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД							
Тогтвортой, хариуцлагатай, ил тод төрийн албыг төлөвшүүлнэ.							
1.	1.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	1.1.1 Аймаг, орон нутагт дутагдалтай байгаа нарийн мэргэжлийн боловсон хүчний дэлгэрэнгүй судалгааг гарган, төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах.	2016-2020	ТЗУХ, хэлтэс, агентлаг, Сумдын Засаг дарга	“Дундговь аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах”, “Оюунлаг Дундговь” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн үр дүнг тооцох, хэрэгжилтийн хувиар	Оны эхэнд сумын хэмжээнд төрийн байгууллагад дутагдалтай байгаа 23 боловсон хүчний судалгааг гаргаж олон нийтийн цахим хэрэгслээр ажлын байрны зар мэдээллийг байршуулж ажилласан. Төрийн захиргааны сул ороны тоог нөхөхөөр аймгийн ТАСЗ-д шаардлагатай материалыг хүргүүлсэн. Сумын хэмжээнд сул орон тооны мэдээллийг олон нийтэд ил тод цахим хэрэгсэл болон мэдээллийн самбараар хүргэж ажилласнаар энэ оны эцсийн байдлаар 17 сул орон тоог байнгын болон түр тушаал шийдвэрээр нөхөөд байна. 2020 оны 12 сарын байдлаар суманд дутагдалтай байгаа боловсон хүчний судалгааг гаргахад 5 байгууллагад 6 албан хаагч дутагдалтай байгаа бөгөөд үүнээс төрийн захиргааны 1, төрийн үйлчилгээний албан 5 хаагч байна. “Дундговь аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах” аймгийн төлөвлөгөөнд шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүрт гарган хүргүүлсэн. Тус суманд одоо ажиллаж байгаа албан хаагчид, шилжин ирж байгаа болон шинээр ажилд орж байгаа албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр анхаарч төвийн халаалтанд холбогдсон орон сууцаар хангах, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх,	100

					мэргэжил эзэмшихэд нь цалинтай чөлөө олгох зэргээр дэмжиж ажилласан. Төсвийн байгууллагууд дотооддоо хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар төлөвлөгөөтэй ажилладаг. Тухайлбал ЗДТГ-аас нэг ажилтанг боловсролын зэрэг ахиулах сургалтанд хамрууллаа. Соёлын төвийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжмийн багш Ц.Мөнгөнчимэгийг “Сити” дээд сургуулийн Хөгжмийн багшийн 2 дугаар курст эчнээгээр суралцуулж байна. Хүүхдийн цэцэрлэгээс Мэргэжлийн бус албан хаагч нараас 1 ажилтанг мэргэжил сургалтын төвд танхимаар болон онлайнаар суралцуулж байна. 1 ажилтанг мэргэжлийн багшийн сургалтад 3 дахь жилдээ хамруулж, албан хаагч нарыг тогтворт сууршилтай ажиллах боломжийг бүрдүүлж байна. ЕБСургуулиас дотуур байрны тогооч тэтгэвэртээ гарч буй учир тогоочийн мэргэжилтэй ажилтангаа чадваржуулах төлбөртэй онлайн сургалтанд сургаж дараагийн залгамж ажилтанг бэлтгэсэн. 2 багшид хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилласны мөнгөн тэтгэмжинд хамрагдсан.		
2.		1.1.2 Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангахад хуулийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийн баталгаа гаргаж, мөнгөн дэмжлэг үзүүлэх.	2016-2020	ТЗУХ Сумдын Засаг дарга	Орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо урьд оноос нэмэгдсэн байна.	Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцлийн талаар судалгаа явуулсан. 73 төрийн албан хаагчийн 9,8% нь байгууллагын орон сууцанд, 11% нь хувийн байшинд, 50% нь гэрт, 16,6% нь нийтийн орон сууцанд, 12,5% нь хувийн орон сууцанд амьдарч байна. Шинээр гэр, байшин барьж амьдрах орчноо сайжруулсан 2 албан хаагчид 400000 төгрөгийн тусламж үзүүлсэн. Одоогоор ямар нэгэн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт өгсөн албан хаагч байхгүй байна.	100
3.		1.1.3 Төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулж, мэргэшүүлэх сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлэх.	2016-2020	ТЗУХ, хэлтэс, агентлаг	Гадаад дотоодын сургалт, арга хэмжээнд хамрагдсан ТАХ-ын тоо өмнөх оноос 5%-иар өссөн байна.	Дэлхий нийтэд үүссэн коронавирусын халдвараас шалтгаалан төрийн албан хаагчдад зориулсан төлөвлөгөөт сургалт семинар төдийлөн зохион байгуулагдаагүй. ЗДТГ-аас 9 мэргэжилтэн албан хаагчид 2-3 удаагийн семинарт хамрагдсан байна. 1	100

				Сумдын Засаг дарга нар		албан хаагч боловсролын зэрэг ахиулах 1,5 жилийн сургалтанд хамрагдсан. Хүүхдийн цэцэрлэгээс орон нутагт зохион байгуулсан танхимын сургалтад 1 удаа, онлайн сургалтад 3 удаа хамрагдаж, туршлага судлах үйл ажиллагааг 1 удаа, илтгэлийн уралдаанд 1 удаа оролцлоо. Нийт 6 удаагийн орон нутгийн сургалтад танхим болон онлайнаар албан хаагчдын 63% хамрагдсанаар мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн. Төрийн албан хаагчдыг дотоодод сургах, чадавхийг дээшлүүлэхэд 300000 төгрөгийн томилолт, замын зардалд 60л шатахууныг олгосон. ЕБС-ийн багш нр Улаанбаатар хотод туршлага судлах ажилд 10 багш хамрагдаж “Тояа” хүүхэд хөгжлийн сургалтын академийн “Хувь хүний хөгжил” сэдэвт лекц, цээж тооллыг хөгжүүлэх, хурдан бодолтын арга, хурдан уншилтын сургалтанд хамрагдаж хичээлд хэрхэн ашиглах зэрэг олон сонирхолтой аргуудыг сурлаа. Мөн Ганзам 20-р сургуулийн Монгол Улсын Зөвлөх багш С.Болормаагийн хичээлд сууж нэг өдрийн багшийн үйл ажиллагаатай танилцан туршлага судаллаа. Багшийн хүүхэдтэй ажиллах эв дүй, хичээлийн зохион байгуулалт, хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэл, дасгал даалгавар, хүүхэд бүхэнд хүрч ажилладаг аргаас залуу багш ихээхэн зүйлийг тусган авлаа. ЭМТ-ийн их эмч Д.Пунсалдулам эхоны эмчээр 1 сарын чиглүүлэх сургалтанд, их эмч О.Энхмаа ЭХЭМҮТ-д хүүхдийн эмчийн 1 сарын дээшлүүлэх сургалтанд, Б.Мөнхтамир ЭХЭМҮТ-д 3 сарын хүүхдийн сувилагчаар мэргэжил дээшлүүлсэн.	
4.		1.1.4 Багийн Засаг дарга нарыг унаажуулах ажлыг үе шаттай шийдвэрлэх.	2016-2020	ТЗУХ Сумдын Засаг дарга	2012-2019 онд нийт 67 БЗД нарын 89,6 %-ийг унаажуулсан цаашид нэмэгдүүлсэн хувиар	Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.6-д тусгагдсаны дагуу 2018 онд 4-р багийн Засаг дарга Д.Мягмардорж, 2019 онд 3-р багийн Засаг дарга Г.Дэмбэрэлжав нарт мотоцикл олголоо.	100

5.		1.1.5 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар иргэдэд ил тод, шуурхай, хүртээмжтэй, үйлчилгээг хүнд сурталгүй хүргэх, цахим засаглалыг бодитойгоор хэрэгжүүлэх.	2016-2020	ТЗУХ, хэлтэс, агентлаг, Сумдын Засаг дарга	Төрийн цахим үйлчилгээний “Хур системийг 6 суманд нэвтрүүлсэн байна	2020 оны 5 сарын 27-нд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн газраас зохион байгуулсан “Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх “Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэх, систем нэвтрүүлэх” сургалтанд ЗДТГ-ын Архив, бичиг хэргийн ажилтанг хамруулсан. Сумын ЗДТГ-т “Хур” системийг нэвтрүүлснээр 54 төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос чирэгдэлгүйгээр хүргэх нөхцлийг бүрдүүлж 30 иргэнд лавлагаа хуулбар олгосон. Сумын ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээгээр давхардсан тоогоор 1147 иргэн, 768 өрх, 30 гаруй хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэсэн байна. Сайн дурын даатгуулагч шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлэх, шимтгэлийн төлбөрөө төлөхөд гар утсандаа “Нийгмийн даатгал” аппликэйшнийг суулгаж дээрх үйлчилгээнүүдийг орон зай, цаг хугацааны хамааралгүй авахаас гадна шимтгэл төлөлтөө гар утаснаасаа хянах боломжтой болсон тухай мэдээллийг иргэдэд хүргэсэн. Нийгмийн халамжийн цахим системд шилжсэн 6 төрлийн тэтгэмжийн талаар иргэдэд мэдээллийг цахим болон утсаар, биечлэн хүргэх ажлыг зохион байгуулж 240 иргэнийг дансжуулах, картжуулах ажлыг 100% зохион байгуулсан. Татварын удирдлагын нэгдсэн системийг 2019 онд ашиглалтад оруулж нэгдсэн мэдээллийн баазтай болж мэдээлэл солилцооны хурд нэмэгдэж, татвар төлөгчдөд хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн. Татварын тайлан илгээх, татвараа бүх банкуудын интернэт банкаар төлөх, QRay ашиглах, и-баримт аппликейшн ашиглаж төрийн бүх л үйлчилгээг авч болох, төлбөр тооцоог хийх замаар иргэдэд ил тод, шуурхай үйлчилгээг хүнд сурталгүй хүргэж, цахим засаглалыг бодитойгоор хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна. Мал эмнэлэгийн нэгдсэн системтэй болж мал эмнэлэгийн арга хэмжээ болон	100
----	--	--	-----------	--	---	---	-----

						Мал эмнэлэгийн гарал үүслийн гэрчилгээг цахим хэлбэрээр малчид, иргэдэд олгож байна. Байгууллагын дарга нарын тушаал, захирамжийг 2009-2020 он хүртэл нийт 120 гаруй баримтыг шивж, скайнердаж цахим хэлбэрт шилжүүлснээр хуулбар лавлагааг цахимаас шууд хэвлэж өгч байна. Улсын бүртгэлийн онлайн системээр иргэдэд лавлагаа мэдээллийг түргэн шуурхай ил тод хүргэж ажиллалаа.	
6.		1.1.6 Төрийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын хяналтыг бий болгож, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.	2016-2020	Бүх хэлтэс Сумдын Засаг дарга	ТББ байгууллагуудтай гэрээ байгуулж, хамтарч ажиллаж иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хяналт тавих боломжийг бий болгож тэдгээрийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	Төрийн үйл ажиллагаанд ялангуяа ОНХС, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад иргэд, иргэний нийгмийн байгууллын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг томилон ажлын гүйцэтгэлийн байдалд хяналт тавин ажилласан байна. Тухайлбал Соёлын төвийн барилгын явцад хяналт тавьж ажиллаж байна.	70
7.	1.2 Хууль ёсыг бэхжүүлэх	1.2.1 Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангасан тогтолцоог бэхжүүлж, иргэдийн эрхийг хангах.	2016-2020	ХЭЗХ, Аймгийн ЗД-ын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сум	Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр боловсруулах, батлахдаа төслийн шатанд иргэдээ сонсох, саналыг нь авах, хэлэлцүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн эрхийг хамгаална.	Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй болно.	30
8.		1.2.4 Иргэд, олон нийтийн оролцоотой Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх шатанд авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ил тод, нээлттэй, итгэл даах байдлыг хангах.	2016-2019	ОНТ ОНХС, хөтөлбөр	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийн хувийг улсын дунджаас бууруулахгүй, шударга байдлын түвшний үнэлгээг ахиулна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа. 2020 онд нийтийн албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдийн судалгааг шинэчлэн гаргаж цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан. СХС-ийн зээл олгох ажиллагаанд төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбар 1, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн 5 мэдэгдэл тайлбар, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр болон ОНХС-ийн	100

						гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зэрэгт ашиг сонирхлын зөрчилгүй тухай нийт 7 мэдэгдэл гаргуулж цахимд шивсэн байна. 2019 оны ХАСХОМ-ыг холбогдох төрийн албан хаагчдаар гаргуулан цахимд шивж хуулийн хугацаанд тайлан мэдээг гаргаж хүргүүлсэн байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилж Ашиг сонирхол харандаа, ХАСХОМ харандаа шторкыг албан хаагчдад танилцуулсан. 2020 онд шинээр томилогдсон 3 албан хаагчийн ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж дүгнэлтийн үндсэн дээр томилж, томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ыг цахимаар авч баталгаажуулсан.	
9.		1.2.6 Архивын баримт бичгийн 90 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах.	2016-2020	-Хэлтэс, агентлаг, сум -ТББ - Авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөл	Төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ашиглалт сайжирч, мэдээлэл, үйлчилгээ шуурхай болно. Гүйцэтгэлийн хувиар	Мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр албан байгууллагын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн, албан байгууллагын дарга нарын тушаал, захирамжийг 2009-2020 он хүртэл нийт 120 гаруй баримтыг шивж, скайнердаж цахим хэлбэрт шилжүүллээ. CD дискэнд буулгаж хамгаалалтын болон ашиглалтын цахим хувьтай боллоо. Цахим сангаас нийт 25 иргэнд лавлагаа олгосон байна.	100
10.	1.3 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх	1.3.3 Аймгийн хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг, оролцоог сайжруулж, иргэдийн өмчийн хулгайн болон гудамж талбайд	2016-2020	ХЭЗХ, Цагдаагийн газар, аймгийн ГХУСАЗС Зөвлөл, Бүх шатны Засаг дарга,	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь нэмэгдэж, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурна.	Сумын хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх теле камерийн системийг сайжруулах чиглэлээр албан мэдэгдлийг өгч үр дүнг тухай бүр нь тооцон ажилласан. Иргэн аж ахуйн нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг, оролцоог сайжруулж, иргэдийн өмчийн хулгайн болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлыг тогтмол зохион байгуулж ажилсны үр дүнд энэ төрлийн гэмт хэрэг эрс буурсан. Нийтийн	70

		үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг эрс бууруулах.		албан байгууллага, аж ахуй нэгж		эзэмшлийн орон сууц, хүүхдийн талбай, машины зогсоол, гэр хорооллын гудамж талбайг камержуулах саналыг 2021 оны орон нутгийн хөгжлийн санал асуулганд оруулсан.	
11.		1.3.4 “Архигүй Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлж архидалтгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн иргэд болон иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих.	2016-2020	Сумдын ГХУСАЗС 3, Хуулийн байгуллагууд, Мэргэжлийн ТББ, ЭМГ, АА нийгэмлэг	“Архидалтгүй аймаг–Дундговь” (2018-2020) аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт эрчимжиж, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын чанар, хүртээмж сайжирч согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчил өмнөх оноос буурсан байна.	Цагаандэлгэр сумын хэмжээнд Архидалтгүй аймаг-Дундговь хөтөлбөрийн хүрээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдэд гэмт хэрэг, зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. COVID-19-тэй холбоотой Аймгийн засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/68 дугаартай захирамжийн хүрээнд мөн Сумын засаг даргын А/08 дугаартай захирамжийн хүрээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг 2 аж ахуй нэгжийн архи согтууруулах ундааг сар бүрийн 05, 15, 25 –ны өдрүүдэд тоолож лацдан ажиллаж байна. Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг тогтмол зохион явуулж байна. УИХ-ын сонгууль, Орон нутгийн ээлжит сонгуулийн өдрүүд болон covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлж аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын шийдвэрээр 2020 оны 12 дугаар сарын 31 хүртэл архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглож лацдан, хяналт тавьж ажилласан.	100
12.		1.3.5 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх шатны	2016-2020	ГБХЗХГ. БСГ. ДЗөн ОУБ-ын ОНХХ. Аймаг	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд бүх шатны төрийн болон	Сумын хэмжээнд онцгой хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй иргэд, хүүхдүүд гэр орондоо байнга түгшүүр төрүүлдэг этгээдүүдийн судалгааг шинчилэн гаргаж хараа хяналт тавин ажиллаж байна. Хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд өртөхөөс урьдчилан	100

		төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, салбар дундын байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг сайжруулах.		сумын Засаг Дарга, ИТХ, ТББ	төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх танхимтай болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.	сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавин хамтарсан багийг сар бүр хуралдуулж хамтын ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл болон хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан бий болгосон. Хамтарсан багийн гишүүд сумын хэмжээнд байгаа 12 өрх 21 хүүхдэд 313200 төгрөгийн хүнс тэжээлийн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн. Сургууль, цэцэрлэгээс 13 өрхөд 1627850 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн. Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан гэртээ үлдэж байгаа бага насны хүүхдүүдийн хараа хяналтыг сайжруулах, аливаа эрсдлээс хамгаалж төрийн байгууллагууд 0-5 насны хүүхэдтэй эцэг, эхэд цалинтай чөлөө олгож, гэрээс нь ажиллуулах, богиносгосон цагаар ажиллуулах зэргээр хамтран ажиллалаа.	
13.		1.3.6 Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг мэдээллийн сүлжээнд холбох, алба хаагчдыг унаажуулах, согтуурал хэмжигч багаж, бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэж, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх.	2016-2020	ЦГ, Сумдын ИТХ, Засаг дарга,	Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албыг тээврийн хэрэгсэл, 5-аас доошгүй сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн алба хаагчдыг бүрэн унаажуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдэнэ.	Мэдээллийн сүлжээнд холбох ажлыг 2020 оны 5-р сард нэвтрүүлсэн. Цагдаагийн хэсэг мотоцикл, согтуурал шалгах драгер багаж, бэлэн бусын торгуулийн багажтай болсон. ЗДТГ-аас иргэдээс ирсэн дуудлага мэдээллийг цаг алдалгүй очиж шалгах боломжоор хангаж 480 литр шатахуун олгосон. ЗДТГ-ын албан хэрэгцээний хуучин Ланд 100 маркын машиныг цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд хэрэглэж байна. Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу интернэтийн төлбөрийн асуудлыг шийдвэрлэсэн. Иргэдийн 4,6 сая төгрөгийн хандив дэмжлэгээр цагдаагийн хэсгийн байрны гадна дотно орчин нөхцлийг сайжруулж засварлан тохижуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаад байна.	100

14.		1.3.7 Мал сүргийг хамгаалах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж малын хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулах.	2016-2020	Малчдын бүлэг нөхөрлөл, Сумдын ГХУСАЗС 3	Малчдын нөхөрлөлийн ажиллагааг тогтмолжуулж, малын хулгайн гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурна.	Малчдын бүлэг үйл ажиллагааг тогтмолжуулж, малын хулгайн гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурна.	2017 оноос 4 багийн мал хамгаалах малчдын бүлгийг сонгон ажиллуулж байна. Оны эхэнд мал хамгаалах малчдын 6 бүлгүүдэд зөвлөгөөн хийж үүрэгжүүлэн идэвхижүүлж хууль эрх зүйн чиглэлийн сургалт сурталчилгааны материалаар хангасан. 4 багийн Засаг дарга нартай хамтран мал хамгаалах малчдын бүлгүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг. 4 багийн айл өрхийн малын им тамганы судалгааг гаргаж эзэнтэй болон эзэнгүй малын бүртгэлийг нэн даруй гарган ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдсан “МАЛ МАХ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хяналтын пост гарган ажиллаж малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан.	100
-----	--	--	-----------	--	--	--	--	-----

Хоёр . ЭДИЙН ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД

Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан 21 аймгийн дундаас дээш төвшинд хүргэнэ.

15.	2.2. Төсөв санхүү	2.2.1 Төсвийн сахилга батыг сайжруулж, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн өр авлагагүй ажиллах.	2016-2020	СТСХэлт эс, Төсвийн захирагч нар	-Төсөв хэмнэгдсэн байна - Төсвийн өр, авлагагүй байна.	2019 оны жилийн эцэст өр авлагын насжилсан судалгааг гаргаж өр, авлага барагдуулах ажлыг зохион байгуулсан. 2020 оны 12-р сарын байдлаар СХСангийн төгрөгний авлагаас СХСангийн хугацаа болоогүй зээл, зээлийн хүүгийн авлага 112.864.564 төгрөг байна. СХС-ын 2017 онд тавигдсан 75,134,256 төгрөгийн актыг 87,4 хувьтай биелүүлж зээлээ төлөөгүй 4 иргэний материалыг шүүхийн байгууллагад шилжүүлж зээлийг албадан төлүүлэхээр болсон. 2020 онд мал хамгаалах сангийн авлага барагдуулах ажлыг зохион байгуулж нийт 7,500,000 төгрөгний авлагыг барагдуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг зөрчилгүй гаргасан байна. Төсөвт байгууллагууд өр авлага үүсгэхгүй ажилласан байна.	100
-----	-------------------	---	-----------	----------------------------------	---	--	-----

16.		2.2.2 Төсвийн зарцуулалтад тавих хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотой гүйцэтгүүлж, шилэн дансны тогтолцоог бүрэн хэрэгжүүлжүүлэх.	2016-2020	СТСХэлт эс, Төсвийн захирагч нар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	-Шилэн дансанд хуулийн хугацаанд холбогдох мэдээллийг тогтмол байршуулж санхүүгийн илт байдлын үзүүлэлт өмнөх оноос 10%-иар өсгөж ард иргэдэд илт тодоор мэдээллэж ажиллана .	Төрийн аудитын газарт жил бүр шилэн дансны хэрэгжилтэнд аудит хийлгэж зөвлөмжийн дагуу алдаа зөрчлийг арилгасан. Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс 2020 оны 7 сард санхүүгийн дотоод хяналт хийж шилэн дансны үйл ажиллагааг шалгасан. Уг хяналтаар сумын хэмжээнд шилэн дансны үйл ажиллагаа хэвийн гэсэн зөвлөмж өгсөн.	100
-----	--	---	-----------	--	---	--	-----

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг хангаж, нийгмийн баталгааг нь сайжруулна.

17.	3.2 Боловсрол	3.2.10 “Хүүхдэд ээлтэй дотуур байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	2017-2020	НБХ, БСУГ, Сумдын ЗДТГ	Хөтөлбөрийн хүрээнд сургуулийн дотуур байранд суух хүсэлтэй суралцагчдыг 100% хамруулан, дотуур байрны орчин нөхцөл сайжирсан байна.	1.Дотуур байрын суралцагчдын эрүүл, аюулгүй амьдрах, сурч хөгжих орчин бүрдүүлэх - Дотуур байрын гаднах хашааг шинэчлэн шинээр барьсан бөгөөд дотуур байрнаас сургууль орох замд явган хүний замыг тавьж тохижуулах бүтээн байгуулалтын ажлыг хамт олноороо хийж эмх цэгцтэй орчин бүрдсэн. - Галын аюулгүй ажиллагааг тогтмол ханган ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. Галын аврах бүдүүвч зургийг гарган мэдээллийн самбарт харагдахуйц байршуулсан бөгөөд галын булантай болсон. - Сурагчдын гар нүүр, хувцасаа угаах орчин бүрдүүлж индүүдлэг хийх хатаах орчин бүрдүүлэхийн тулд угаалтуурын өрөөндөө насны онцлогт тохирсон 3 ширхэг угаалтуур хийж байрлуулсан. - Гадна талбайд хүүхэд чөлөөт цагаа өнгөрөөх, амрах, тоглох орчин бүрдүүлж мод тарьж ургуулж байна.	100
-----	---------------	---	-----------	------------------------	--	---	-----

						2.Хүүхэд бүрийн онцлогийг харгалзсан хүртээмжтэй, хөгжих төлөвших , зөв дадал хэвшилтэй болох • 2019-2020 оны хичээлийн жилд дотуур байранд 15 сурагч хамрагдсан. Үүнээс 9 эмэгтэй, 6 эрэгтэй эдгээр сурагчдын дэлгэрэнгүй судалгааг авсан. Мөн сурагчдын зан төлөвийн судалгаанд 15 сурагч, эрсдэлийн судалгаанд 14 сурагч, тэдгээрийн гэр бүлийн байдлыг судлан судалгааны сан бүрдүүлсэн. • Сурагчид сонирхлоороо сургуулиас зохион явуулж байгаа секц дугуйланд хамрагдсан байна. Тухайлбал: Шатрын дугуйланд 6 сурагч, гар бөмбөгийн дугуйланд 4 сурагч тус тус хамрагдсан. • Хүүхдийн өөрийн удирдлагын бүлэг байгуулж даргаар М.Анужин 5 гишүүнтэй ажиллаж байгаа бөгөөд ариун цэвэр эрүүл ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлсэн байна. • Хүүхдийн хүмүүжил төлөвшил харилцаа хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын хуваарийн дагуу сургалтуудыг зохион байгуулсан. Жишээлбэл: Насан туршийн боловсролын багш Н.Оюунцэцэгтэй хамтран “Цагийг зөв ашиглах нь” сэдэвт сургалтыг үйлчлэгч, дотуур байрын сурагчдад амжилттай зохион байгуулсан. Эрүүл мэндийн төвийн эмлэгч эмч Д.Пунсалдулам Томуу өвчин гэж юу вэ сургалтыг зохион явуулж нийт сурагчдад витамин с тарааж мэдээлэл хийв. 3.Багш ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх • Байрын багшийн эхний 1 жилийн үндсэн сургалтанд бүртгүүлж, онлайн даалгавраа хийн хичээлээ үзэж шалгалтуудыг өгсөн. Онлайн хичээлээр Сурган хүмүүжүүлэх зүй Мэдээлэл харилцааны технологи	
--	--	--	--	--	--	---	--

						Хичээл төлөвлөлт гэсэн 3 агуулгаар хичээлээ судалсан. Дотоод журмыг хэлэлцэн баталж жилийн төлөвлөгөө баталж, улирал бүрийн тайланг танилцуулсан. 4.Сэтгэл ханамжийг судалж судалгааны мөрөөр ажиллах • Санал хүсэлтийн хайрцаг ажиллуулсан. Энэ хичээлийн жилд сурагчдаас 2 санал ирсэн бөгөөд түүнийг шийдвэрлэж хариу мэдээлэл өгсөн. • Тогоочтой хамтран хоолны амт чанар, хүртээмжийг судлах судалгааг улирал бүр авч ирсэн саналыг харгалзан үзэж 7 хоног бүрээр шинэ меню гарган ажиллаж хэвшээд байна. • Өрөөний тохижилт, багш ажилтны харилцаа зэрэг үе шаттай асуулгууд авч түүний мөрөөр ажиллаж байна. Энэ хичээлийн жилд 15 сурагч, эцэг эхээс нь сэтгэл ханамжийн судалгааг авсан.	
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД							
Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.							
18.	4.1 Мал аж ахуй, газар тариалан	4.1.1 “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.	2017-2021	ХХААГ Сумдын Засаг дарга	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэнэ.	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Тэргүүн сүрэг” ХХК-тай гэрээ байгуулан сумын бог малын хээлтүүлэгч, бухыг ээмэглэх ажил зохион байгуулахад 1156200 төгрөг зарцуулан ажиллалаа. Ээмэгний үнийг тухайн компани дансанд 100 хувь төвлөрүүллээ. Мөн бод малыг хэмжих палк метр, бог мал хэмжих палк метр, лентметр, циркуль зэрэг багаж тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэн өгсөн байна.	70
19.		4.1.4 Бэлчээрийн даацад тулгуурлан мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн	2020	ХХААГ, ХОХБТХ	Үлийн цагаан оготно тархсан 12 сумын 50 мян.га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулж	Бэлчээрийн үлийн цагаан оготныг энгийн механик аргаар устгах ажлыг сумын Засаг даргын 2020 оны А/35 тоот захирамжаар Сумын орлогч дарга Э.Арьяабазараар ахлуулсан 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон 2020 оны 05-	100

		менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.		Сумын ЗДТГ-ууд	бэлчээрийн даац, багтаамжийг нэмэгдүүлнэ	р сарын 01-ны өдрөөс 2020 оны 05-р сарын 10-ны өдрийг хүртэл оготно устгах ажлыг зохион байгуулж ажилласан. Ажлыг Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн “Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах” ажлын удирдамжийн дагуу зохион байгуулсан. Оготно устгах ажлыг эхлүүлэхийн өмнө бүх ажиллах бүрэлдэхүүнд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, технологийн зааврыг Байгаль орчны байцаагч Д.Ганчимэг, ЖДҮ, бэлчээр хариуцсан мэргэжилтэн Ё.Мядагмаа нар танилцуулж гарын авлага материалыг тараан гарын үсэг зурлуулсан. Мөн албан хаагч, малчидыг эмчийн үзлэгт оруулсан. Сумын 9,0 мянган га талбайд / Хараат баг 2,5 мян га, Дэлгэрэх зам баг 2,5 мян га, Жаргалан баг 2,0 мян га, Замын –Улаан баг 2,0 мян га/ улсын төсвийн 14,400,000 төгрөгний хөрөнгөөр хийсэн. Гэрээгээр ажилгүйдэлд бүртгэлтэй 1 иргэнтэй гэрээ байгуулж ажиллуулсан. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготно устгалын ажлыг байгальд халгүй энгийн механик ус цутгах, утаагаар утах, шувууны үүр тавих аргаар нэгэн зэрэг хийж гүйцэтгэсэн. Устгалын ажилд портер-12ш, жижиг машин 2, мотоцикль 8 ашиглан төрийн албан хаагч 36, малчид иргэд 32 нийт 22 техникийн хэрэгсэл, 68 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Ажилласан бүрэлдэхүүнд ажлын бээлий 258ш, маск 100, хамгаалалтын хувцас 27 олгосон. Оготно устгах багаж тоног төхөөрөмжийн хувьд ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 3 ширхэг үлий цөмлөгч, 10 утагч багажыг ашигласан. Оготно устгалын зардлаас 3,680,000 төгрөгний өртөг бүхий 6 ширхэг утагч багаж, 2 ширхэг үлий цөмлөгч, 4 ширхэг тоннын савыг худалдан авч сумын хэмжээнд оготно устгалын 16ш утагч багаж, 4ш тоннын сав, 5ш үлий цөмлөгчтэй болсон. Сумын 2 иргэнээр 20ш шувууны суулт хийлгүүлсэн. Дээрх ажилчид ажиллах хугацаандаа аюулгүй ажиллах зааврыг нэг бүрчлэн мөрдөж ямар	
--	--	--	--	----------------	--	---	--

						нэгэн зөрчил гаргаагүй.Тайланг 3 хувь гарган холбогдох газаруудад хүргүүлсэн.	
20.		4.1.5 Тэмээний амьдын ашиг шим /ноос, сүү, уналгаа эдэлгээ/-ийг нэмэгдүүлж, тэмээгээ өсгөсөн сум баг малчдыг дэмжиж ажиллах.	2017-2020	ХОХБТХ ХХААГ, Сумдын ЗДТГ	Тэмээн сүргийн тоо толгой өсгөж, ноос, сүүний гарц, амьдын жин нэмэгдүүлсэн байна.	Сумын хэмжээнд тэмээ өсгөх талаар багийн иргэдийн нийтийн хурлаар хөтөлбөрийг танилцуулан ажиллалаа. 2020 онд 93 ботго бойжуулсан байна.	70
21.		4.1.6 Аймгийн хэмжээнд жилдээ 10-аас доошгүй гүний худаг, 30-аас доошгүй гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг тогтмол нэмэгдүүлэн хяналт тавьж,нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг бэлчээрийн худагт суурилуулах.	2016-2020	ХОХБТХ ХХААГ, Сумдын Засаг дарга	Аймгийн хэмжээнд 25-аас доошгүй гүний худаг, 30-аас доошгүй гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг өмнөх оноос 1,5 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.	Суманд гүн өрмийн худаг гаргах байсан боловч төсөвт тусгагдаагүйн улмаас хийгдээгүй байна. Мөн малчид өөрийн хөрөнгөөр энгийн уурхайн 3 худаг сэргээн засварлаж бэлчээр усжуулах арга хэмжээ зохион байгууллаа.	70
22.		4.1.7 Аймгийн хэмжээнд өндөр ашиг шимт сүүний чиглэлийн аж ахуйг хөгжүүлэн, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим хүртээмжийг сайжруулах.	2017-2020	ХХААГ Сумдын Засаг дарга	Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй болон тэмээний аж ахуйг дэмжиж, өндөр ашиг шимт малын тоог 10-аар нэмэгдүүлнэ.	Сүүний чиглэлийн үхэр бойжуулах чиглэлээр сум хөгжүүлэх сангаас 1-р багийн иргэн Т.Төр-эрдэнэ 7,5 сая төгрөгийн зээлд хамрагдан үйл ажиллагаа явуулж байна.	30
23.		4.1.8 Гахай, шувууны туслах аж ахуйг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих.	2017-2020	ХХААГ Сумдын Засаг дарга нар	Гахай, тахиа, шувууны, аж ахуй эрхлэх хүсэлтээ ирүүлсэн 2- оос доошгүй ААН, иргэнд хөрөнгө санхүү, мэдлэг олгох дэмжлэг үзүүлнэ.	4-р багийн иргэн Б.Балжинням сум хөгжүүлэх сангаас тахианы аж ахуй хөгжүүлэхээр төсөл бичин төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж 5,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.	30

24.		4.1.10 ХАА-н биржийн үйл ажиллагааг тогтмол явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, биржийн арилжааг орон нутагтаа хөгжүүлэх.	2016-2020	ХХААГ Сумдын Засаг дарга	Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодоор дамжуулан үндэсний үйлдвэрт нийлүүлсэн бүтээгдэхүүнийг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	Тус сумаас 2020 онд үндэсний үйлдвэрт ноос тушааж урамшуулалд хамруулахаар Уран нинж ХХК-д 11 өрхийн 3549 кг хонины ноос, Чойр хайрхан ХХК-д 25 өрхийн 6868 кг хонины ноос, 1 өрхийн 50 кг тэмээний ноос, Дулаанбэлэг хоршоонд 52 өрхийн 16199 кг хонины ноос, Үлэмж кашмер ХХК-д 62 өрхийн 17022 кг хонины ноос, Жи Эс Эф ХХК-д 9 өрхийн 5050 кг хонины ноос, Сор кашмер ХХК-д 24 өрхийн 7695 кг хонины ноос, Хатант интернэшил ХХК-д 3 өрхийн 897 кг хонины ноос, 1 өрхийн 110 кг тэмээний ноос, Бампүлс ХХК-д 2 өрхийн 1090 кг хонины ноос, Интернэшил ХХК-д 3 өрхийн 816 кг хонины ноос тус тус тушаан урамшуулалд хамрагдах болсон байна. 141 өрхийн 51551 кг хонины ноосонд, 3 өрхийн 310 кг тэмээний ноосонд, 317 малчин, мал бүхий иргэдийн 64566 ямааны ноолууранд тус тус урамшуулал бодогдон олгогдлоо.	100
25.		4.1.11 Малын эмчийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэх боломжийг бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулах.	2017-2020	МЭГ Сумдын Засаг дарга	Төрийн мал эмнэлэгт ажиллагсадын тоо 40-д , хувийн 50 МЭҮН үйл ажиллагаа явуулж мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн чадавхи бэхжинэ. Боловсон хүчний хангалтыг 100 хувьд хүргэнэ.	Мал эмнэлгийн чиглэлээр “Буянт мал сүрэг”, “Цаст ундарга” мал эмнэлгүүд аймгийн Мал эмнэлгийн газар, сумын Засаг дарга, Мал эмнэлгийн тасагтай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн 2020 онд шинээр Ө.Жаргалсайхан “Хос эрдэнэн уул” мал эсмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулан малчидтай гэрээ байгуулан ажиллаж байна.	100
26.	4.2 Үйлдвэр	4.1.12 Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бруцеллёз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.	2017-2020	МЭГ Сумдын Засаг дарга	Гоц халдварт 1,0 сая, халдварт 900,0 мянга, бруцеллезоос сэргийлэх арга хэмжээнд 700,0 мянган мал хамруулан дархлаажуулна.	Мал эмнэлгийн дархлаажуулалтын арга хэмжээг тухай бүр сумын Засаг даргын захирамж гарган хэрэгжүүлж ажиласан бөгөөд Шөвөг яр 14398 төл, Сахуу 751 унага даага, Дуут хавдар 491 үхэр, Дотрын халдварт хордлого 15409 бог, Галзуу 991 бог, Бруцеллёз 48002 төл, Шүлхий 299557 малыг тус тус хамруулсан байна.	100

[illegible]

Байгалийн нөөцийг зохистой ашиглан, нөхөн сэргээж аялал жуулчлал, уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.							
31.	5.3 Ашигт малтмал, уул	5.3.1 Бичил уурхай эрхлэгчдийг осол аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай ажиллуулж, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргийг өндөржүүлэх.	2017-2020	ХОХБТХ, МХГБОА ЖГ Сумдын Засаг дарга	4 сумын 56 нөхөрлөлийн БОМТөлөвлөгөөний хэрэгжилтэд нь хяналт тавьж 10-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийлгэнэ.	Тус суманд бичиг уурхай эрхлэгч иргэн, нөхөрлөл байхгүй.	100
ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД							
Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлаж, хүн ардын ая тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулахад чиглүүлнэ.							
32.		6.2.8 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгаж, шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг засварлах буюу шинээр барих.	2017-2020	НБХ ГХБХБГ ХОХБТХ Сумын Засаг дарга	Өлзийт сумын 250 суудалтай соёлын төвийн барилгын угсралтын ажлыг 80 хувь, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумдын соёлын төвийн барилгын угсралтын ажлыг 30 хувь, Дэрэн, Хулд сумдын соёлын төвийн барилгын их засварын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ.	Сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын ажлыг “Хэрмээдэй” ХХК 1,228 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна.	30
	Үнэлгээ 100 хувь-19, 70 хувь-7, 30 хувь-6						80,3

НЭГТГЭСЭН: НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА
ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА

О.НАНДИН-ЭРДЭНЭ
З.СОЛОНГО
Д.БУДЖАВ

